



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/143НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Гэрэлт хөхийн тэнцвэр аудит ХХК-ны аудитор: Д.Нарантуул Утас:99019800 Цахим хаяг: ntuul9800@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг

Утас/Факс: (976)-7043-3061

Email: khovd@audit.gov.mn

2026.01.29 № 30

танай _____-ны № _____-т

АЛТАЙ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
М.ЦЭЦЭГМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд хүүхэд өдрийн төлөвлөгөө 24549 өдрөөр батлагдаж гүйцэтгэлээр 20832 хүүхэд буюу 84.8 хувьтай, улсын төсвөөс 809,994.7 мянган төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч гүйцэтгэлийн үнэлгээнд 3 дугаар түвшинд 3 багш, 4 дүгээр түвшинд 2 багш үнэлэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

8426050016
A4-1001-2026

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлттэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 бүлэг 11 зорилт 33 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>194,649,015.73</u>	<u>96,862,359.58</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	152,799,247.33	60,428,533.58
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	152,799,247.33	60,428,533.58
3121	Төгрөг	152,799,247.33	60,428,533.58
31211	Төрийн сангийн харилцах	152,799,247.33	60,428,533.58
33	АВЛАГА	167,006	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	167,006	-
35	БАРАА МАТЕРИАЛ	41,682,762.40	36,433,826
351	Түүхий эд материал	515,000	716,250
35130	Эм боох материал	515,000	716,250
354	Хангамжийн материал	41,167,762.40	35,717,576
35410	Бичиг хэргийн материал	425,500	740,500
35420	Аж ахуйн материал	24,576,362.40	13,357,346
35460	Хүнсний материал	6,915,200	4,788,030
35470	Бусад хангамжийн материал	9,250,700	16,831,700
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>595,400,818.03</u>	<u>600,035,636.42</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	595,400,818.03	600,035,636.42
392	Биет хөрөнгө	588,670,818.03	593,305,636.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	558,622,317	569,834,392
39202	Хуримтлагдсан элэгдэл	(60,949,668.72)	(71,965,868.30)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	82,289,758	86,758,112
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,654,653.72)	(41,550,594.80)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,635,982.50	82,658,098.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(39,234,858.03)	(37,662,368.98)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	271,925
39217	Ном	4,961,941	4,961,941
393	Биет бус хөрөнгө	6,730,000	6,730,000
39301	Програм хангамж	300,000	300,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(300,000)	(300,000)
39303	Бусад биет бус хөрөнгө	6,730,000	6,730,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>790,049,833.76</u>	<u>696,897,996</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>790,049,833.76</u>	<u>696,897,996</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	790,049,833.76	696,897,996
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	291,600,833	291,600,833
51101	Өмч: - төрийн	291,600,833	291,600,833
512	Хуримтлагдсан үр дүн	285,198,994.12	192,047,156.36
51210	Өмнөх үеийн үр дүн	285,198,994.12	267,234,427.72
51220	Тайлант үеийн үр дүн	-	(75,187,271.36)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	213,250,006.64	213,250,006.64
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>790,049,833.76</u>	<u>696,897,996</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	935,563,300	914,793,654
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,621,800	43,850,554
120	Нийтлэг татварын бус орлого	25,452,600	43,850,554
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,452,600	43,850,554
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	25,452,600	43,850,554
122	Тусламжийн орлого	16,169,200	-
122001	Хандив тусламж /дотоод/	16,169,200	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	893,941,500	870,943,100
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	837,437,000	809,994,700
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	837,437,000	809,994,700
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,504,500	60,948,400
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,504,500	60,948,400
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	818,748,275.16	989,980,925.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	818,748,275.16	989,980,925.36
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	804,069,156.28	981,363,297.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	562,289,038.48	705,134,191.34
210101	Үндсэн цалин	361,262,551.48	431,030,263.21
210102	Нэмэгдэл	171,475,199	222,461,302.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	20,220,000
210104	Урамшуулал	29,551,288	31,422,626
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	67,990,090.51	87,837,342.41
210201	Тэтгэврийн даатгал	46,302,635.15	60,655,719.38
210202	Тэтгэмжийн даатгал	5,533,091.05	7,119,737.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,021,471.08	3,918,130.53
210204	Ажилгүйдлийн даатгал	2,589,760.51	3,222,355.12
210205	Эрүүл мэндийн даатгал	10,543,132.72	12,921,400.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,680,181.12	56,624,072.08
210301	Гэрэл, цахилгаан	4,311,297.97	6,304,472.08
210302	Түлш, халаалт	39,444,603.15	39,444,600
210303	Цэвэр, бохир ус	7,924,280	10,875,000
2105	Нормативт зардал	74,332,450	67,714,160
210502	Хоол, хүнс	74,332,450	67,714,160
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,200,000
210604	Урсгал засвар	-	2,200,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,889,000	1,392,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,889,000	1,392,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,888,396.17	60,461,531.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,415,760.00	20,723,320.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	6,355,836.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,472,636.17	33,382,375.61

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,679,118.88	8,617,627.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,104,800	6,493,300
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,104,800	6,493,300
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,574,318.88	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,574,318.88	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,124,327.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,124,327.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	116,815,024.84	(75,187,271.36)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	116,815,024.84	(75,187,271.36)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	910,110,700	870,943,100
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,169,200	-
122	Тусламжийн орлого	16,169,200	-
122001	Хандив тусламж /дотоод/	16,169,200	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	893,941,500	870,943,100
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	837,437,000	809,994,700
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	837,437,000	809,994,700
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,504,500	60,948,400
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,504,500	60,948,400
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	747,474,088.99	963,313,813.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	747,474,088.99	963,313,813.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	732,794,970.11	954,696,185.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561,358,850.29	708,894,769.71
210101	Үндсэн цалин	365,283,212.67	424,331,359.23
210102	Нэмэгдэл	166,895,832.68	222,926,014.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	20,000,000
210104	Урамшуулал	29,179,804.94	41,637,395.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,920,278.70	84,076,764.04
210201	Тэтгэврийн даатгал	47,232,823.34	57,199,252.75
210202	Тэтгэмжийн даатгал	5,533,091.05	6,729,700.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,991,951.16	3,365,750.16
210204	Ажилгүйдлийн даатгал	2,619,280.43	3,359,072.16
210205	Эрүүл мэндийн даатгал	10,543,132.72	13,422,988.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,680,181.12	56,624,072.08
210301	Гэрэл, цахилгаан	6,776,585.82	6,304,472.08
210302	Түлш, халаалт	36,979,315.30	39,444,600
210303	Цэвэр, бохир ус	7,924,280	10,875,000
2105	Нормативт зардал	-	67,068,520

210502	Хоол, хүнс	-	67,068,520
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,250,000	2,200,000
210604	Урсгал засвар	1,250,000	2,200,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,264,000	3,892,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,480,000	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,784,000	3,892,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,321,660	31,940,060
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,918,460	25,355,610
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,403,200	6,584,450
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,679,118.88	8,617,627.92
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,104,800	6,493,300
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,104,800	6,493,300
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,574,318.88	2,124,327.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,574,318.88	2,124,327.92
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	162,636,611.01	(92,370,713.75)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	162,636,611.01	(92,370,713.75)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		152,799,247.33
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	152,799,247.33	60,428,533.58

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	291,600,833	213,250,006.64	285,198,994.12	790,049,833.76
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	291,600,833	213,250,006.64	285,198,994.12	790,049,833.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(17,964,566.40)	(17,964,566.40)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	291,600,833	213,250,006.64	267,234,427.72	772,085,267.36
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(75,187,271.36)	(75,187,271.36)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	291,600,833	213,250,006.64	192,047,156.36	696,897,996.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл

2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	991,186,600	961,189,485.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	991,186,600	961,189,485.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	984,693,300	954,696,185.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	721,327,100	708,894,769.71
210101	Үндсэн цалин	441,172,000	424,331,359.23
210102	Нэмэгдэл	249,084,600	222,926,014.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	20,000,000
210104	Урамшуулал	31,070,500	41,637,395.77
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,525,700	84,076,764.04
210201	Тэтгэврийн даатгал	60,757,100	57,199,252.75
210202	Тэтгэмжийн даатгал	7,192,100	6,729,700.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,596,100	3,365,750.16
210204	Ажилгүйдлийн даатгал	3,596,100	3,359,072.16
210205	Эрүүл мэндийн даатгал	14,384,300	13,422,988.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,748,100	56,624,072.08
210301	Гэрэл, цахилгаан	8,417,100	6,304,472.08
210302	Түлш, халаалт	39,456,000	39,444,600
210303	Цэвэр, бохир ус	10,875,000	10,875,000
2105	Нормативт зардал	76,466,300	67,068,520
210502	Хоол, хүнс	76,466,300	67,068,520
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,200,000	2,200,000
210604	Урсгал засвар	2,200,000	2,200,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,068,000	3,892,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,068,000	3,892,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,358,100	31,940,060
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,397,800	25,355,610
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,960,300	6,584,450
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,493,300	6,493,300
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,493,300	6,493,300
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,493,300	6,493,300
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	991,186,600	868,818,772.08
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	815,526,900	809,994,700
131001	Улсын төсвөөс санхүүжих	815,526,900	809,994,700
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	60,948,100	58,824,072.08
132001	Орон нутгийн төсвөөс	60,948,100	58,824,072.08
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	114,711,600	-
1E+06	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	114,711,600	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		152,799,247.33
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		60,428,533.58
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25
620001	Удирдах ажилтан	2	2
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17
620003	Үйлчлэх ажилтан	6	6
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15	15

650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9

ГУРАВ . АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ :

Аудитаар нийт 74,877.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 48,619.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үнэ төлбөргүйгээр шилжиж ирсэн 5,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй,
- Эд хариуцагчийн хоолны талоны түүвэрт 1,350.0 мянган төгрөгийн махыг илүү зарлагдсан,
- Өмнөх оны үйл ажиллагаанд зарцуулагдсан 17,964.5 мянган төгрөгийн бараа материалыг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрсөн,
- Дахин үнэлгээ хийгдээгүй хөрөнгийг актлаж данс бүртгэлээс хасахдаа 150.2 мянган төгрөгөөр дахин үнэлгээний нэмэгдэл дансыг бууруулсан,
- Тайлант үеийн үр дүн 24,154.3 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн,

Залруулагдаагүй нийт 26,258.5 мянган төгрөгийн 5 зөрчил нь тогтоосон бөгөөд хүүхдийн ирцийн бүртгэлийн зөрүүтэй холбоотой 19,203.0 мянган төгрөгийн зөрчил нь материаллаг бус зөрчил тул үлдэх 7,055.5 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 26,258.5 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 5,405.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, 20,853.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

3.1.1 Бараа материалын зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хүүхдийн хоолны норм норматив мөрдөөгүй 4,006.3 мянган төгрөгийн хүнсний материалыг илүү зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.1.төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; " 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний 237 дугаар тогтоолын 1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 3000 (гурван мянга) төгрөгөөр, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”; гэж заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

3.1.2 Цалин урамшуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын удирдлага нь нягтлан бодогчийн ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэн үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олгосон, цэцэрлэгийн эрхлэгчийн 2025 оны 09 дүгээр сарын 22 өдрийн Б/44 тоот тушаалаар санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан гэх үндэслэлээр 1,241,744 (Нэг сая хоёр зуун дөчин нэг мянга долоон

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зуун дөчин дөрөв) төгрөгийн балансын урамшуулал гэсэн утгаар давахардуулан олгож буцаан суутгаагүй, авлагаар бүртгээгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

3.1.3 Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн хөрөнгөөр хуулиар зөвшөөрөгдөөгүй гарын тос, өндөр үнэтэй бал, тэмдэглэлийн дэвтэр болон бусад материал худалдан авч 157,500 төгрөгийг төсвөөс төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.1-т “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;” 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15.1.5-д “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлгэ дурсгалын зүйл худалдан авах;” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1 Хүүхдийн ирцийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Боловсрол мэдээллийн esis.edu.mn системд илгээсэн 2025 оны 03-12 саруудын хүүхдийн ирцийн тоо мэдээг байгууллагын багш нарын өдөр тутамд хөтөлдөг “бүлгийн ирц бүртгэл”-ийн журналын тоотой тулгахад 6401 хүүхэд өдрөөр зөрүүтэй бүртгээгдэж 19,203,000 төгрөгийн зардлыг гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;” 16.5.4-д “төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;” 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;”, БШУЯ-ны 2020 оны 3/1557 дугаар албан бчиг “Боловсролын салбарын удирдлага мэдээллийн систем”-ийн www.esis.edu.mn цахим системийг ашиглан бүртгэх тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Боловсролын мэдээллийн esis.edu.mn цахим бүртгэлд тухай бүрд мэдээллийг үнэн зөв оруулах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх,

3.2.2 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд дотоод хяналтын багийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу үр дүнтэй зохион байгуулаагүй, 2025 оны 9 дүгээр сарын 23-26 ны өдрүүдийн хоолны талоныг 7 хоногоор баталсан хоолны цэстэй тулгахад хүнсний материалыг зөрүүтэй олгосон, бүтээлч ажлын удирдамжид ажлаа дүгнэх, урамшуулал, үр чадвар олгох шалгуур үзүүлэлтийг тодорхой тусгаагүй үр чадварын нэмэгдлийг олгосон, тэтгэвэрт гарч байгаа багш ажилчидтай эцсийн тооцоо хийгээгүй дотоод хяналт хэрэгжүүлээгүй нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын 3.6-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ", 3.7-д "Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь дараахь нийтлэг эрх, үүрэгтэй байна" 3.7.1-д "зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах", 3.7.3-д " илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах;" Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх;" 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналтын төлөвлөгөөнд тусгасны дагуу хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, үр дүн тооцон ажиллах

3.2.3 Санхүүгийн программ хангамжтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн программыг шинэчлэн Си Ти Эс ХХК-ний СТС санхүүгийн программыг №ТА25/003 дугаартай гэрээ байгуулан ашиглаж, данс бүртгэлд тусгаагүй Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө" гэж тус тус заасан байна. Ажил гүйлгээ үйл явцыг мөнгө хүлээн авсан эсвэл төлсөн эсэхээс үл хамааран орлогыг олсон үед, зардлыг гарсан үед нь хүлээн зөвшөөрч бүртгэх ба холбогдох хугацааны санхүүгийн тайланд тайлагнана. 14.-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэсэн заалтуудтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийг данс бүртгэл тусгах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв . Аудитаар илэрсэн буюу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Запруулсан		Запруу лаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Алтай сумын Хүүхдийн цэцэрлэг	5	48,619.0	1	5,000.0	4	43,619.0	5	48,619.0	-	-	-	-
Дүн	5	48,619.0	1	5,000.0	4	43,619.0	5	48,619				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Алтай сумын Хүүхдийн цэцэрлэг	5	26,101.0	2	5,248.0			3	20,853.0	-	-	-	-
Дүн	5	26,101.0	2	5,248.0	-	-	3	20,853.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ мян.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Байгууллагын хөрөнгөөр хуулиар зөвшөөрөгдөөгүй бусад зардлыг төлсөн (гарын тос, өндөр үнэтэй бал, тэмдэглэлийн дэвтэр)	1	157.5	1	157.5						
Дүн	1	157.5	1	157.5						
Нийт дүн										

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	-	1	-	-	1	-	-	-
НИЙТ			1	-	-	1	-	-	-